

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/243-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Т.Одсүрэн Цахим хаяг: odsurent@audit.gov.com
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Албан шаардлага.....	18
4.3 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ШШБ</b>	Шүүх шинжилгээний байгууллага
<b>ШШҮХ</b>	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.17 № СЭА-2022/243-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,990,697.00</b>	<b>10,485,931.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6,990,697.00</b>	<b>10,485,931.00</b>
35100	Түүхий эд материал	230,000.00	3,135,080.00
35130	Эм боох материал	230,000.00	3,135,080.00
35400	Хангамжийн материал	6,760,697.00	7,350,851.00
35410	Бичиг хэргийн материал	-	134,600.00
35420	Аж ахуйн материал	6,117,300.00	6,345,300.00
35440	Түлш, шатах тослох материал	479,197.00	145,951.00
35470	Бусад хангамжийн материал	164,200.00	725,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>49,535,515.81</b>	<b>44,008,478.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>49,535,515.81</b>	<b>44,008,478.73</b>
39200	Биет хөрөнгө	49,535,515.81	44,008,478.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,400,000.00	53,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,133,333.36)	(36,700,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,171,699.00	50,621,499.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,963,984.31)	(25,296,531.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,801,014.29	10,801,014.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,739,879.81)	(8,817,502.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>56,526,212.81</b>	<b>54,494,409.73</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>56,526,212.81</b>	<b>54,494,409.73</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	56,526,212.81	54,494,409.73
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	27,632,196.00	27,632,196.00
51200	Хуримтлагдсан үр дүн	28,894,016.81	26,862,213.73
51210	Өмнөх үеийн үр дүн	21,500,998.03	28,894,016.81
51220	Тайлант үеийн үр дүн	7,393,018.78	(2,031,803.08)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>56,526,212.81</b>	<b>54,494,409.73</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>294,172,006.34</b>	<b>292,823,495.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,498,306.34</b>	<b>8,965,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>20,498,306.34</b>	<b>8,965,500.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>9,058,040.61</b>	<b>6,965,500.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,884,236.00	5,208,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,173,804.61	1,757,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,440,265.73	2,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>273,673,700.00</b>	<b>283,857,995.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>266,223,700.00</b>	<b>274,390,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	266,223,700.00	274,390,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,450,000.00</b>	<b>9,467,895.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,450,000.00	500,000.00

**Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,499,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,467,995.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>286,778,987.56</b>	<b>294,855,298.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>286,778,987.56</b>	<b>294,855,298.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>284,720,470.85</b>	<b>291,893,012.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>232,612,900.87</b>	<b>242,352,887.94</b>
210101	Үндсэн цалин	136,162,155.37	143,700,209.26
210102	Нэмэгдэл	79,521,589.93	82,364,048.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,929,155.57	16,288,630.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,650,899.92</b>	<b>5,418,319.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	392,144.17
210202	Тэтгэмжийн даатгал	-	46,134.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	58,700.00	36,907.69
210204	Ажилгүйдлийн даатгал	91,300.00	9,226.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,500,899.92	4,933,905.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,500,000.00</b>	<b>5,802,439.95</b>
210302	Түлш, халаалт	2,844,592.78	1,302,439.95
210304	Байрны түрээс	2,655,407.22	4,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,939,029.50</b>	<b>11,193,733.00</b>
210401	Бичиг хэрэг	2,847,598.00	2,634,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,701,181.00	4,476,043.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,637,500.50	1,847,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	148,400.00	137,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,336,550.00	1,881,650.00
210408	Бараа материал акталсны зардал	1,267,800.00	216,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,965,553.00</b>	<b>7,016,440.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,724,453.00	7,016,440.00
210502	Хоол, хүнс	1,241,100.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,537,250.00</b>	<b>1,234,180.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,844,750.00	750,000.00
210604	Урсгал засвар	692,500.00	484,180.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,143,600.00</b>	<b>3,000,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	4,143,600.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,066,320.00</b>	<b>1,898,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,400.00	1,299,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	291,100.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	251,323.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	31,000.00	40,000.00
210807	Газрын төлбөр	8,820.00	173,102.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,304,917.56</b>	<b>13,976,837.08</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,304,917.56	13,976,837.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,058,516.71</b>	<b>2,962,285.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00

**Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,058,516.71	2,462,285.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,516.71	2,462,285.95
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>7,393,018.78</b>	<b>(2,031,803.08)</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>7,393,018.78</b>	<b>(2,031,803.08)</b>
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,632,196.00	21,500,998.03	49,133,194.03
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,632,196.00	21,500,998.03	49,133,194.03
9	Тайлант үеийн үр дүн	-	7,393,018.78	7,393,018.78
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,632,196.00	28,894,016.81	56,526,212.81
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	27,632,196.00	28,894,016.81	56,526,212.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,632,196.00	28,894,016.81	56,526,212.81
19	Тайлант үеийн үр дүн	-	(2,031,803.08)	(2,031,803.08)
20	2021 оны 06-р сарын 30-наарх үлдэгдэл	27,632,196.00	26,862,213.73	54,494,409.73

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>281,557,936.00</b>	<b>289,066,495.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,884,236.00</b>	<b>5,208,500.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	7,884,236.00	5,208,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,884,236.00	5,208,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,884,236.00	5,208,500.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>273,673,700.00</b>	<b>283,857,995.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>266,223,700.00</b>	<b>274,390,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	266,223,700.00	274,390,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,450,000.00</b>	<b>9,467,895.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,450,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,499,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,467,995.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>274,111,036.00</b>	<b>282,616,695.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>274,111,036.00</b>	<b>282,616,695.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>272,052,519.29</b>	<b>279,654,409.05</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>232,612,900.87</b>	<b>242,352,887.94</b>
210101	Үндсэн цалин	136,162,155.37	145,535,759.02

**Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210102	Нэмэгдэл	79,521,589.93	80,528,498.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,929,155.57	16,288,630.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,650,899.92</b>	<b>5,418,319.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	392,144.17
210202	Тэтгэмжийн даатгал	-	46,134.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	58,700.00	36,907.69
210204	Ажилгүйдлийн даатгал	91,300.00	9,226.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,500,899.92	4,933,905.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,500,000.00</b>	<b>5,802,439.95</b>
210302	Түлш, халаалт	2,844,592.78	1,302,439.95
210304	Байрны түрээс	2,655,407.22	4,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,908,098.50</b>	<b>13,550,787.00</b>
210401	Бичиг хэрэг	3,085,800.00	2,943,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,917,300.00	4,142,797.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,663,398.50	1,847,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	148,400.00	137,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,093,200.00	4,478,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,633,500.00</b>	<b>6,397,620.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,392,400.00	6,397,620.00
210502	Хоол, хүнс	1,241,100.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,537,200.00</b>	<b>1,234,180.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,844,700.00	750,000.00
210604	Урсгал засвар	692,500.00	484,180.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,143,600.00</b>	<b>3,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,143,600.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,066,320.00</b>	<b>1,898,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,400.00	1,299,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	291,100.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	251,323.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	31,000.00	40,000.00
210807	Газрын төлбөр	8,820.00	173,102.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,058,516.71</b>	<b>2,962,285.95</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,058,516.71	2,462,285.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,516.71	2,462,285.95
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>7,446,900.00</b>	<b>6,449,800.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,446,900.00</b>	<b>6,449,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,446,900.00</b>	<b>6,449,800.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	7,446,900.00	6,449,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,446,900.00	6,449,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(7,446,900.00)</b>	<b>(6,449,800.00)</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>277,990,100.00</b>	<b>277,136,314.05</b>	<b>853,785.95</b>	<b>99.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>277,990,100.00</b>	<b>277,136,314.05</b>	<b>853,785.95</b>	<b>99.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>277,990,100.00</b>	<b>277,136,314.05</b>	<b>853,785.95</b>	<b>99.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>242,944,300.00</b>	<b>242,352,887.94</b>	<b>591,412.06</b>	<b>99.76</b>
210101	Үндсэн цалин	143,950,200.00	145,535,759.02	(1,585,559.02)	101.10
210102	Нэмэгдэл	81,142,100.00	80,528,498.90	613,601.10	99.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,852,000.00	16,288,630.02	1,563,369.98	91.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,593,800.00</b>	<b>5,418,319.16</b>	<b>175,480.84</b>	<b>96.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	312,400.00	392,144.17	(79,744.17)	125.53
210202	Тэтгэмжийн даатгал	36,800.00	46,134.61	(9,334.61)	125.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,400.00	36,907.69	(7,507.69)	125.54
210204	Ажилгүйдлийн даатгал	7,400.00	9,226.93	(1,826.93)	124.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,207,800.00	4,933,905.76	273,894.24	94.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,810,000.00</b>	<b>5,802,439.95</b>	<b>7,560.05</b>	<b>99.87</b>
210302	Түлш, халаалт	1,310,000.00	1,302,439.95	7,560.05	99.42
210304	Байрны түрээс	4,500,000.00	4,500,000.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,952,000.00</b>	<b>12,941,297.00</b>	<b>10,703.00</b>	<b>99.92</b>
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	2,943,900.00	(643,900.00)	128.00
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	3,562,307.00	637,693.00	84.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,890,000.00	1,847,740.00	42,260.00	97.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	137,400.00	12,600.00	91.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,412,000.00	4,449,950.00	(37,950.00)	100.86
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,500,000.00</b>	<b>5,497,620.00</b>	<b>2,380.00</b>	<b>99.96</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,500,000.00	5,497,620.00	2,380.00	99.96
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>750,000.00</b>	<b>750,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.00	750,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,440,000.00</b>	<b>1,373,750.00</b>	<b>66,250.00</b>	<b>95.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	999,800.00	200.00	99.98
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	133,950.00	66,050.00	66.98

**Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	40,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	-	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>277,990,100.00</b>	<b>278,744,814.05</b>	<b>(754,714.05)</b>	<b>100.27</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>274,390,100.00</b>	<b>273,536,314.05</b>	<b>853,785.95</b>	<b>99.69</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	274,390,100.00	273,536,314.05	853,785.95	99.69
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,600,000.00</b>	<b>5,208,500.00</b>	<b>(1,608,500.00)</b>	<b>144.68</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,600,000.00	5,208,500.00	(1,608,500.00)	144.68
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>16.00</b>	<b>16.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>16.00</b>	<b>16.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	16.00	16.00	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,467,895.00</b>	<b>9,467,895.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,018,095.00</b>	<b>3,018,095.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,518,095.00</b>	<b>2,518,095.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>609,490.00</b>	<b>609,490.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210402	Тээвэр, шатахуун	580,490.00	580,490.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,000.00	29,000.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>900,000.00</b>	<b>900,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	900,000.00	900,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>484,180.00</b>	<b>484,180.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	484,180.00	484,180.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>524,425.00</b>	<b>524,425.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	300,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,323.00	151,323.00	-	100.00
210807	Газрын төлбөр	73,102.00	73,102.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,449,800.00</b>	<b>6,449,800.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

**Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,449,800.00</b>	<b>6,449,800.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,449,800.00	6,449,800.00	-	100.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,467,895.00</b>	<b>9,467,895.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,467,895.00</b>	<b>9,467,895.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	500,000.00	-	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,499,900.00	2,499,900.00	-	100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,467,995.00	6,467,995.00	-	100.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний алба /цаашид Шүүхийн шинжилгээний алба гэх/-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 13Ө/09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шинжилгээний албаны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

**Зорилго:** Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.

**Зорилт:** Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах, шинжээч нарын мэргэжлийн ур чадвар болон мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, үзлэг, шинжилгээний чанарт онцгой анхаарч хуулийн хугацааг нарийн баримтлан шинжээчдийн бие даасан хараат бус байдлыг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,

- 2 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- 3 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шинжилгээний албаны бүтэц зохион байгуулалтын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Харин ШШҮХ-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2021 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу байгууллагын тээвэр шатахууны зарцуулалтад хяналт шалгалт хийж, шинээр томилогдсон нягтлан бодогчийг сургалтад хамруулан, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 286,704.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,867,0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,006.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,031.8 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	6,990.7	10,485.9	3,495.2
Үндсэн хөрөнгө	49,535.5	44,008.5	(5,527.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>56,526.2</b>	<b>54,494.4</b>	<b>(2,031.8)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	56,526.2	54,494.4	(2,031.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>56,526.2</b>	<b>54,494.4</b>	<b>(2,031.8)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд 10,485.9 мянган төгрөг болж 3,495.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх нэг удаагийн /нэг удаагийн өмсгөл, бээлий, маск, улавч, малгай нүдний шил, цогцсын уут, ариутгалын бодис/ хамгаалах хэрэгслийн нөөцийн үлдэгдлээс шалтгаалсан байна.

Он дамжсан, материаллаг хэмжээний үлдэгдэлтэй, ашиглагдаагүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 114,822.5 мянган төгрөг болж 8,449.8 мянган төгрөгөөр өссөн нь хуульд заасан чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэмэлт төсвийн орлогоос 6,449.8 мянган төгрөгийн компьютер, принтер худалдан авсан болон Сүхбаатар сумын ИТХ-аас 2,000.0 мянган төгрөгийн зургийн аппарат үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 54,494.4 мянган төгрөг болж 2,031.8 мянган төгрөгөөр бурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,345.7 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд албаны бие даасан барилгатай болох саналыг тусган хөрөнгийн зардлыг төсөвлөснөөр өмнөх оны гүйцэтгэлээс 70 хувиар нэмэгдүүлж 449,745.6 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гэвч төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хөрөнгө оруулалтын зардлыг хасаж, төсвийн саналыг 175,355.5 мянган төгрөгөөр бууруулж, төсвийн санхүүжилтийг 274,390.1 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 3,600.0 мянган төгрөгөөр, нийт **277,990.1** мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **277,990.1** мянган төгрөгийн төсөв баталснаас 274,390.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,600.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 274,390.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,208.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, нийт 279,598.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **277,136.3** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн санхүүжилтээс 853.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 1,608.5 мянган төгрөг зэрэг нийт 2,462.3 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 277,136.3 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 591.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 175.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 86.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-ын даргын А/23 дугаар захирамжаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ашиглах зориулалтаар тоног төхөөрөмж худалдан авахад 2,499.9 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 6,468.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/37 дугаар захирамжаар онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр хуулиар хүлээсэн чиг үүргээ хариуцлагатай хэрэгжүүлж, амжилттай ажилласан албан хаагчдыг шагнаж урамшуулахад зориулж 500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Шүүх шинжилгээний тухай хуулийн 42.3-т "Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь **цагдаагийн** дүрэмт хувцас, цол хэрэглэж, ялгаж тэмдэгтэй байх..." гэж заасан атал албан хаагчдын цолны нэмэгдлийг Зэвсэгт хүчний цолны нэмэгдэл олгох журмыг баримтлан олгож байна.

**3.7.2** ШШҮХ-ийн захирлын 2017 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шинжилгээний байгууллагын шагналын журам"-ын дагуу албан хаагчдад шагнал олгохдоо нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас бус цалингийн зардлаас санхүүжүүлж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

**3.7.3** Байгууллагын даргын шийдвэрээр 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад ШШҮХ-ийн захирлын 2021 оны Б/600 дугаар тушаалаар тухайн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг хангалттай үнэлүүлсэн гэх үндэслэлээр үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай зөрчилдөж байна.

**3.7.4** Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" болсон 29,396.3 мянган төгрөгийн, 10 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байгаа УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49 дэх "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд "0" үлдэгдэлтэй

хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүх шинжилгээний албаны мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 1 мэдээлэл / цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 1 дүгээр сард /-ийг 1 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.


Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 274.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан болон шилэн дансны мэдээллийг 5 удаа хоцроож байршуулсан зэрэг 2 зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. / Тайланд онд шилэн дансны мэдээллийг 1 удаа хоцроосон нь материаллаг бус гэж үзсэн болно /

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**3.11.1** Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 27,45.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн 1,481.9 мянган төгрөгийн худалдан авалт орж шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,735.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,608.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,257.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 8,619.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгөгдлөө.

##### 4.1 Залруулсан алдаа

**4.1.1** Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг бүртгэхдээ орлогын төлөвлөгөөнөөс давсан 1,608.5 мянган төгрөгийн орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлээр нь бодитоор тайлагнаагүй, орлого бууруулах бичилт хийсэн алдааг залрууллаа.

##### 4.2 Төлбөрийн акт

**4.2.1** Шүүхийн шинжилгээний албаны даргын тушаалаар 2 албан хаагчид цалин нэмэх, 3 албан хаагчид цалин хасах чиглэлээр гарсан шийдвэрийг гүйцэтгэхдээ тогтоосон хувь хэмжээг баримтлаагүйгээс 653.4 мянган төгрөгийн нэмэгдэл, 604.5 мянган төгрөгийн суутгалыг дутуу тооцож, олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, тус албаны даргын 2021 оны Б/02, Б/03, Б/04, Б/05, Б/06, Б/08, Б/09 дугаар тушаалууд болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд илүү болон дутуу олгосон цалинг нөхөн тооцох төлбөрийн акт тогтоох.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** Тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийн дагуу нэр төрлөөр бус бөөн дүнгээр 8,619.3 мянган төгрөгийн ажил гүйлгээ цахим системд шивэгдсэн байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын

Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4317143998

МОН АТЭС 2063126

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүх шинжилгээний алба	3	11,485.7	1	1,608.5	1	1,257.9			1	8,619.3
	<b>Нийт</b>	<b>3</b>	<b>11,485.7</b>	<b>1</b>	<b>1,608.5</b>	<b>1</b>	<b>1,257.9</b>			<b>1</b>	<b>8,619.3</b>